

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШХА	Швецарийн Хөгжлийн агентлаг
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА-3
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Г.ЗОЛБОО
ТАНАА

2020.03.13 № 06/784
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой амьжиргаа - 3 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тогтвортой амьжиргаа - 3 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тогтвортой амьжиргаа – 3 төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төслийн зохицуулагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. Mv

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Тогтвортой амьжиргаа -3 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал Г.Золбоо Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн тайлант жилийн ажил гүйлгээг иж бүрэн бүртгэж байх, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ХХОАТ-ын хуулинд заагдсан татварын хөнгөлөлт эдлүүлэх тухай 23 дугаар зүйл, НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан НӨАТ-аас чөлөөлөх тухай заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн захирал санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 27-ноос 2020 оны 03 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Мүүрь Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 571 дугаар бүхий албан бичгээр Мүүрь Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тогтвортой амьжиргаа – 3 төсөл нь Монголын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой.

Төсөл нь зээл болон буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр санхүүжигддэг.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА) болон Монгол Улсын Засгийн газар (Сангийн Яам төлөөлж оролцсон)-ын хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр төслийг хэрэгжүүлэхээр Зээл№5487-MN тоот Санхүүжилтийн Хэлэлцээр байгуулагдсан. Зээлийн нийт дүн нь 16,100.0 мянган зээлжих тусгай эрхтэй.

Мөн Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА) ба Олон Улсын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ОУСБХБ) болон Монгол Улсын Засгийн газар (Сангийн Яам төлөөлж оролцсон)-ын хооронд 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдөр төслийг санхүүжүүлэх TF0A0794-MN тоот Хамтын Санхүүжилтийн Тусламжийн Хэлэлцээр байгуулагдсан. Уг хэлэлцээрийн дагуух нийт тусламжийн санхүүжилтийн дүн нь 11,365.0 мянган ам.доллар юм. Энэхүү гэрээнд зааснаар 2019 оны 06 дугаар сарын 30 дуусталх хугацаанд буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр төслийг санхүүжүүлнэ.

Төсөл нь 2015 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Төсөл дуусах хугацаа 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр байна.

Төсөл нь зорилгыг хэрэгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

Бүрэлдэхүүн 1: Орон нутгийн засаглал, амьжиргааны чадавхыг бэхжүүлэх

- a) Орон нутгийн засаг захиргаа, иргэд, бүлэг хамт олонд Орон Нутгийн Хөгжлийн Санг хэрэгжүүлэх, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, иргэдийн оролцоо, орон нутгийн төсвийн төслийг боловсруулах ба батлах, төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа ба удирдлага, тайлагналт, хяналт-шинжилгээ болон үнэлгээ, бэлчээрийн төлөвлөлт, удирдлага зэрэг салбараар сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлнэ.
- b) ОНХС-ийн хэрэгжилт, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх эдийн засаг, санхүүжилтийн асуудал эрхэлсэн Захиргааны төв байгууллагад техникийн туслалцаа үзүүлнэ.

Бүрэлдэхүүн 2: Сайн засаглал-Үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөр

- a) ОНХС-ийн үйл ажиллагааг Сайн засаглалын хүрээнд хэрэгжүүлсэн сумдад үр дүнд суурилсан санхүүжилт болон санхүү, хөрөнгө оруулалтын нэмэлт хөрөнгийг хуваарилж, хэрэгжүүлнэ.
- b) Үр дүнд суурилсан санхүүжилтийг сумдад хуваарилах зорилгоор ОНХС-ийн хэрэгжилтэд жил бүр сум тус бүрээр хөндлөнгийн үнэлгээ хийнэ.
- c) Сайн засаглалын гүйцэтгэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийх багийг сургалтад хамруулна.

Бүрэлдэхүүн 3: Төслийн удирдлага, Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ

Тогтвортой амьжиргаа хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих техникийн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах, мөн ажлын байрны болон бусад хангамж, эд зүйлс

авах, түүний дотор Төслийн хэрэгжилтийг хангах, төслийн ажилтнуудыг сургах, мэдээ мэдээллээр хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол явуулах, төслийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх, төслийн үйл ажиллагаа, дансанд аудит хийлгэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.

Төслийн нэг ба хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь хоорондоо нягт уялдаатай хэрэгжих бөгөөд эдгээрийг гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийн төслийн удирдлага, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга хэмжээнүүд дэмжих юм.

Тогтвортой амьжиргаа -3 төслийн удирдлага дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Монгол Улс болон Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан зээлийн санхүүжилтийн хэлэлцээр /дугаар Зээл №5487-MN/;
- Дэлхийн банк дахь Олон Улсын Хөгжлийн Ассоциаци /Дэлхийн банк гэх/ ба Олон Улсын Сэргээн Босголт Хөгжлийн Банк болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 07 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан гэрээ /дугаар TF0A0794-MN/;

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн шимтгэлийн хувь хэмжээнд болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлтийн хэмжээ шатлалтай болж өөрчлөлтүүд орсон бөгөөд оны эхнээс мөрдсөн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төсөл нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Төсөл, тусгай сангуудын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн бөгөөд уг журамд нийцсэн байна.

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд SLP finance программ хангамж ашигладаг бөгөөд энэ нь зөвхөн Дэлхийн банканд хүргүүлдэг төслийн тайланг бэлтгэхэд зориулагдсан байна.

Төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Тогтвортой амьжиргаа-3 төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд 6 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 20,499,944.8 мянган төгрөгөөс тооцон 204,989.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд томоохон залруулга хийгдээгүй, санхүүгийн тайлан өөрчлөгдөөгүй тул материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тогтвортой амьжиргаа -3 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 785,355.9 мянган төгрөгөөр буюу 36.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,897,170.1	1,146,956.1	(750,214.0)
Авлага	1,653.0	-	(1,653.0)
Үндсэн хөрөнгө	278,813.9	246,899.0	(31,914.9)
Биет бус хөрөнгө	3,206.3	1,631.3	(1,575.0)
Нийт хөрөнгө	2,180,843.3	1,395,486.4	(785,356.9)
Цэвэр өмч: Хуримтлагдсан үр дүн	2,180,843.3	1,395,486.4	(785,356.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,180,843.3	1,395,486.4	(785,356.9)

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 750,213.9 мянган төгрөгөөр буурсан. Төсөл нь нөхөн дүүргэлтийн зарчмаар санхүүжилт авдаг бөгөөд тайлант оны эцэст гарсан зарцуулалтын нөхөн дүүргэлт хийгдээгүй учраас мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 37.5 хувь буюу 429,579.4 мянган төгрөг нь Төрийн банк дахь санхүүжилт хүлээн авдаг тусгай дансны үлдэгдэл бөгөөд 157,152.38 ам доллар байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,914.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд нэмэгдсэн 126,622.9 мянган төгрөгийн хөрөнгө, балансаас балансад шилжүүлсэн 50,402.9 мянган төгрөгийн хөрөнгө, 109,710.0 мянган төгрөгийн элэгдлээс шалтгаалсан.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 104 тоот тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 50,402.9 мянган төгрөгийн дансны үнэтэй Тоёота ландкрузер-105 маркийн автомашиныг балансаас балансад хүлээн авсан байна.

Уг машиныг 2019 оны 9 дүгээр сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 тоот тогтоолоор Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд хүлээлгэн өгч, тухайн төсөлд ашиглагдаж байсан Лексус-470 маркийн 48,500.0 мянган төгрөгийн дансны үнэтэй, 33,680.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй автомашиныг балансаас балансад хүлээн авсан байна.

Үйл ажиллагааны явцад төслийн санхүүжилтээр 27,720.0 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшил бэлтгэсэн. Данснаас хассан, худалдан борлуулсан хөрөнгө байхгүй.

Тайлант оны элэгдэл 76,029.4 мянган төгрөг байна.

Тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж хуримтлагдсан үр дүн 785,356.9 мянган төгрөгөөр буурсан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн тайлант оны батлагдсан төсөвт 22,061,528.5 мянган төгрөгийн зарлагыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр заасан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (ОУХА) ба Олон Улсын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ОУСБХБ) болон Монгол Улсын Засгийн Газар (Сангийн Яам төлөөлж оролцсон)-ын хооронд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрт заагдсанаар аливаа төлбөрийг мөнгөөр төлсөн үед зардлаар хүлээн зөвшөөрч, санхүүжилтийн нөхөн дүүргэлт хийгддэг учраас санхүүжилт төсөвлөсөн хэмжээнээс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсөл нь хэрэгжих хугацаандаа нийт 35,365.0 мянган ам.долларын санхүүжилтийн эх үүсвэртэй бөгөөд тайлант оны эцсийн байдлаар 21,198.5 мянган ам.долларын санхүүжилт авсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 22,061,528.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 6,861,536.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 15,199,992.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд төслийн үйл ажиллагаанд 20,424,319.7 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 2018 оны хэрэгжилтэнд хийсэн үнэлгээнд үндэслэн, урамшуулал, ерөнхий дэмжлэг олгох тухай Төслийн удирдах хорооны тогтоолоор 222 суманд нийт 4,615,348.0 мянган төгрөгийн урамшуулал, 330 суманд 10,563,044.0 мянган төгрөгийн ерөнхий дэмжлэг олгосон.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалтууд, төслийн зөвлөхийн ажлын хөлс, жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хийх болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд 5,245,927.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 20,424,319.7 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ буюу төслийн зөвлөхийн ажлын хөлс олгоогүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 61,160.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 25,626.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар илэрсэн 35,534.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тогтвортой амьжиргаа -3 төсөл нь 2020 онд хэрэгжиж дуусах бөгөөд төсөл хаагдах үед ТӨБЗГ-ын тогтоолоор үнэ төлбөргүй шилжүүлэн авсан автомашиныг ямар шийдвэр тогтоолоор хэнд шилжүүлсэн болох, төслийн санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх хугацааг сунгах тухай Сангийн сайдын тушаалд заасан хугацааг тухайн үеийн зарцуулалттай тулган шалгах нь зүйтэй гэж үзлээ. Өөр бусад анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Тогтвортой амьжиргаа -3 төсөл нь Шилэн дансны цахим хуудсаар дамжуулан <https://www.shilendans.gov.mn/org/4917?group=0&year=2019/> Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тухай бүрд нь ил тод мэдээлж байсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, хугацаатай зөвлөмж өгөөгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тогтвортой амьжиргаа -3 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Тогтвортой амьжиргаа -3 төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хүүгийн орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төслийн санхүүжилт хүлээн авдаг тусгай данс болон төсөл хэрэгжүүлэх нэгж, орон нутгийн үйл ажиллагааны данс нь Төрийн банкинд байршдаг. Төрийн банк сар бүрийн эцэст харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогыг Сангийн яам болон Төрийн банкны хооронд байгуулсан гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Дээрх хүүгийн орлого болон төвлөрүүлсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэн зөв байх зарчим хангагдаагүй бөгөөд ажил гүйлгээг дутуу бүртгэснээс мөнгөн гүйлгээний тайлан алдаатай гарах, улмаар санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг бүрэн гүйцэд журналд иж бүрэн, үнэн зөв тусгаж байх, харилцах дансны хуулга болон журналын ажил гүйлгээг тухай бүр тулган шалгаж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарна.

3.2 Цалинтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд төслийн зөвлөх, ажилтны цалингаас хувь хүний орлогын албан татварыг суутгахдаа хөнгөлөлтийг дутуу тооцсон байна.

3.2.2 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1 дугаар зүйлд заасан албан татварын хөнгөлөлт эдлүүлэх заалтыг мөрдөөгүй байна. Мөн цалингийн тооцооллыг буруу хийснээс цалин илүү, дутуу олгогдох, улмаар маргаан үүсэх эрсдэлтэй.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Цалингаас суутгах татварыг ХХОАТ-ын тухай хуульд заасны дагуу тооцоолох, жил бүрийн эцэст тухайн ажилтны нийт цалинг нэгтгэн, татварын хөнгөлөлт, суутган тооцолт зөв байгаа эсэхийг хянаж шалгаж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хэрэгжүүлэн ажиллана.

3.3 НӨАТ-тай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Сангийн сайдын 2016 оны 91 тоот тушаалаар төслийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээ нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн. Уг тушаалд заасан НӨАТ-аас чөлөөлөгдөх хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон байна. Тайлант онд төслийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд 11,701.7 мянган төгрөгийн НӨАТ төлсөн байна.

3.3.2. Эрсдэл:

Энэ нь Нэмэгдсэн өртөгийн албан таварын тухай хуулийн 13 дугаар зүйлд “13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө. 13.1.3. Гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа;” гэж заасантай зөрчилдөж байна.

Төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны зардлыг НӨАТ-гүйгээр төлөвлөж, гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох тушаал шийдвэр гараагүйгээс НӨАТ нэмж тооцоологдох, улмаар эх үүсвэргүй өр төлбөр нэмэгдэх эрсдэлтэй.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагад төслийн хугацаа сунгагдсан албан баримтыг хүргүүлж, НӨАТ-аас чөлөөлөгдөх хугацааг сунгуулах шаардлагатай.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Холбогдох Төрийн байгууллагад хүсэлт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 3 сард багтаж шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,898,823,064.69	1,146,956,141.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,897,170,064.69	1,146,956,141.94
311	Кассад байгаа бэлэн мөнгө	286,410.67	300,291.86
31110	Төгрөг	286,410.67	300,291.86
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,896,883,654.01	1,146,655,850.08
3121	Төгрөг	123,959,504.60	717,076,484.96
31211	Төрийн сангийн харилцах	80,589,001.28	712,842,054.68
31213	Арилжааны банк дахь харилцах	43,370,503.32	4,234,430.28
3122	Гадаад валют	1,772,924,149.41	429,579,365.12
31223	Арилжааны банк дахь харилцах	1,772,924,149.41	429,579,365.12
33	АВЛАГА	1,653,000.00	-
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,653,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	282,020,140.02	248,530,200.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	282,020,140.02	248,530,200.81
392	Биет хөрөнгө	278,813,890.02	246,898,950.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,800,000.00	162,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	44,255,555.56	99,597,222.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	208,973,372.00	232,433,690.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	69,154,744.60	112,993,883.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,854,954.54	92,114,654.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	18,404,136.36	27,358,288.48
393	Биет бус хөрөнгө	3,206,250.00	1,631,250.00
39301	Программ хангамж	6,300,000.00	6,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,093,750.00	4,668,750.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,180,843,204.71	1,395,486,342.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,180,843,204.71	1,395,486,342.76
51	Засгийн газрын хувь оролцоо	2,180,843,204.71	1,395,486,342.76
512	Хуримтлагдсан үр дүн	2,180,843,204.71	1,395,486,342.76
51210	Өмнөх үеийн үр дүн	9,168,091,943.98	2,180,843,204.71
51220	Тайлант үеийн үр дүн	(6,987,248,739.27)	(785,356,861.95)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,180,843,204.71	1,395,486,342.76

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,682,203,199.87	19,745,614,181.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,682,203,199.87	19,745,614,181.90
120	Нийтлэг татварын бус орлого	155,813,669.76	40,482,163.15
120002	Хүүгийн орлого	152,099,591.76	25,662,718.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	14,819,444.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	14,819,444.42
120009	Бусад орлого	3,714,078.00	-
122	Тусламжийн орлого	2,773,740,408.30	4,104,358,780.59
122002	Хандив тусламж /гадаад/	2,773,740,408.30	4,104,358,780.59
124	Зээлийн орлого	9,752,649,121.81	15,600,773,238.16
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	9,752,649,121.81	15,600,773,238.16
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	19,691,033,270.67	20,499,944,782.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,691,033,270.67	20,499,944,782.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,515,007,180.67	5,295,890,063.45
2104	Хангамж, бараа материалын зардал	11,876,720.36	16,118,596.81
210401	Бичиг хэрэг	3,756,267.97	250,111.73
210402	Тээвэр, шатахуун	1,710,045.47	6,387,627.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,410,406.92	5,769,957.81
210404	Ном, хэвлэл	-	3,710,900.00
2107	Томилолт, зочны зардал	18,152,272.00	9,894,723.00
210702	Дотоод албан томилолт	18,152,272.00	9,894,723.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,572,611,551.09	5,122,308,719.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,553,802,845.45	5,122,308,719.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,050,430.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,672,832.72	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	251,142.92	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	912,366,637.22	147,568,024.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,377,928.90	71,538,622.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	822,489,358.19	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,499,350.13	76,029,401.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,176,026,090.00	15,204,054,718.73
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	25,662,718.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,662,718.73

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,176,026,090.00	15,178,392,000.00
213404	Хөрөнгийн	17,176,026,090.00	15,178,392,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(7,008,830,070.80)</u>	<u>(754,330,600.28)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	21,581,331.53	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	21,581,331.53	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	31,026,261.67
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	31,026,261.67
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	21,581,331.53	(31,026,261.67)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(6,987,248,739.08)</u>	<u>(785,356,861.95)</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>12,682,203,199.87</u>	<u>19,730,794,737.48</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,682,203,199.87	19,730,794,737.48
120	Нийтлэг татварын бус орлого	155,813,669.76	25,662,718.73
120002	Хүүгийн орлого	152,099,591.76	25,662,718.73
120009	Бусад орлого	3,714,078.00	-
122	Тусламжийн орлого	2,773,740,408.30	4,104,358,780.59
122002	Хандив тусламж /гадаад/	2,773,740,408.30	4,104,358,780.59
124	Зээлийн орлого	9,752,649,121.81	15,600,773,238.16
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	9,752,649,121.81	15,600,773,238.16
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>19,626,618,557.08</u>	<u>20,449,982,398.55</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,626,618,557.08	20,449,982,398.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,450,592,467.08	5,245,927,679.82
2104	Хангамж, бараа материалын зардал	11,876,720.36	15,927,596.81
210401	Бичиг хэрэг	3,756,267.97	250,111.73
210402	Тээвэр, шатахуун	1,710,045.47	6,196,627.27
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,410,406.92	5,769,957.81
210404	Ном, хэвлэл	-	3,710,900.00
2107	Томилолт, зочны зардал	18,152,272.00	9,782,425.00
210702	Дотоод албан томилолт	18,152,272.00	9,782,425.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,574,013,408.17	5,127,815,292.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,555,204,702.53	5,127,815,292.27
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	2,050,430.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,672,832.72	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	251,142.92	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	846,550,066.55	92,402,365.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,419,565.44	92,402,365.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	824,130,501.11	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,176,026,090.00	15,204,054,718.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,176,026,090.00	15,178,392,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,176,026,090.00	15,178,392,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	25,662,718.73
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,662,718.73

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(6,944,415,357.02)</u>	<u>(719,187,661.07)</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	21,581,331.53	(31,026,261.67)
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	21,581,331.53	(31,026,261.67)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>21,581,331.53</u>	<u>(31,026,261.67)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(6,922,834,025.68)	(750,213,922.74)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,820,004,090.37	1,897,170,064.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,897,170,064.69	1,146,956,141.94

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	9,168,091,943.98	9,168,091,943.98
C07	Тайлант үеийн үр дүн	-	(6,987,248,739.27)	(6,987,248,739.27)
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,180,843,204.71	2,180,843,204.71
D08	Тайлант үеийн үр дүн	-	(785,356,861.95)	(785,356,861.95)
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,395,486,342.76	1,395,486,342.76

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,061,528,500.00	20,424,319,679.82	(1,637,208,820.18)	92.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,861,536,500.00	5,245,927,679.82	(1,615,608,820.18)	76.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,861,536,500.00	5,245,927,679.82	(1,615,608,820.18)	76.4
2104	Хангамж, бараа материалын зардал	68,959,000.00	15,927,596.81	(53,031,403.19)	23.1
210401	Бичиг хэрэг	16,620,000.00	250,111.73	(16,369,888.27)	1.5
210402	Тээвэр, шатахуун	6,912,000.00	6,196,627.27	(715,372.73)	89.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,827,000.00	5,769,957.81	(12,057,042.19)	32.4
210404	Ном, хэвлэл	24,000,000.00	3,710,900.00	(20,289,100.00)	15.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	-	(3,600,000.00)	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,723,000.00	-	(3,723,000.00)	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,723,000.00	-	(3,723,000.00)	-
2107	Томилолт, зочны зардал	300,000,000.00	9,782,425.00	(290,217,575.00)	3.3
210701	Гадаад албан томилолт	240,000,000.00		(240,000,000.00)	-
210702	Дотоод албан томилолт	60,000,000.00	9,782,425.00	(50,217,575.00)	16.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,285,824,600.00	5,127,815,292.27	(1,158,009,307.73)	81.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,285,824,600.00	5,127,815,292.27	(1,158,009,307.73)	81.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,029,900.00	92,402,365.74	(110,627,534.26)	45.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,029,900.00	92,402,365.74	(110,627,534.26)	45.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,199,992,000.00	15,178,392,000.00	(21,600,000.00)	99.9
2200	Дотоод эх үүсвэрээр	15,199,992,000.00	15,178,392,000.00	(21,600,000.00)	99.9
222001	Тоног төхөөрөмж	21,600,000.00	-	(21,600,000.00)	-
223001	Бусад хөрөнгө	15,178,392,000.00	15,178,392,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,061,528,500.00	19,705,132,018.75	(2,356,396,481.25)	89.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,882,336,900.00	15,600,773,238.16	(1,281,563,661.84)	92.4
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	16,882,336,900.00	15,600,773,238.16	(1,281,563,661.84)	92.4
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	5,179,191,600.00	4,104,358,780.59	(1,074,832,819.41)	79.3
122002	Хандив тусламж /гадаад/	5,179,191,600.00	4,104,358,780.59	(1,074,832,819.41)	79.3
	БУСАД	-	-	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүү		31,026,261.67	31,026,261.67	-

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,897,170,064.69		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,146,956,141.94		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13	13		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7		
620004	Гэрээт ажилтан	5	5		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Тогтвортой амьжиргаа – 3 төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.06			САГ-2020/704/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Тогтвортой амьжиргаа-3 төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажиллагсдын цалингаас ХХОАТын хөнгөлөлтийг дутуу тооцоолж, татвар илүү суутгасан.	1,120.0	Зөвлөмж өгөх	Төслийн санхүү удирдлагын мэргэжилтэн	Т.Түвшинжаргал
2	Сангийн сайдын тушаалаар баталсан төслийн худалдан авалтын НӨАТ-аас чөлөөлөгдөх хугацаа 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсноор НӨАТ төлсөн.	11,701.7	Зөвлөмж өгөх	Төслийн захирал Нягтлан бодогч	Б.Золбоо Т.Түвшинжаргал
3	Төрийн банкнаас харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого болон дээрх орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн ажил гүйлгээг бүртгээгүй байна.	25,626.3	Залруулсан	Төслийн захирал Нягтлан бодогч	Б.Золбоо Т.Түвшинжаргал
4	Орон нутагт олгосон санхүүжилтийн зарцуулалтын анхан шатны баримт хангалтгүй	22,712.5	Зөвлөмж өгсөн	Төслийн захирал Нягтлан бодогч	Б.Золбоо Т.Түвшинжаргал
	Нийт	61,160.5			

